



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/28

Дэлгэрмөрөн

«Сонор хоёрдугаар багийн “Наран суурийн гүн өрмийн худаг”-ийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороонд өөрчлөлт оруулах тухай


Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх сумын төвийн Сонор хоёрдугаар багийн “Наран суурийн гүн өрмийн худаг”-ийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай 2022 оны А/07 дугаар захирамжид гишүүнээр томилогдсон Ч.Дамдинсандив нь өөр газар ажиллахаар явсан тул үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсугай.

2. Үнэлгээний хорооны гишүүн Ч.Дамдинсандив гэснийг сумын Насан туршийн боловсролын багш Ч.Бямбадорж гэж өөрчилсүгэй.

3. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж, авилга, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллахыг Ч.Бямбадоржид үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сэрдагва)-д даалгасугай.

ДАРГА  С.СУМЪЯАБАЗАР

D /bichig hereg/ Zahiramj -2022 on

642201051